



САР ШИНИЙН МЭНДЧИЛГЭЭ

Айлчлан иржэ буй XVII жарны Гал бичин жилийн сар шинийн баярын мэндийг дэвшүүлж айл хотол, ахан дүүсээрээ эрүүл энх, сайн сайхан байхын ерөөл өргөн мэндчилье.

Увсчууд бидний хувьд хонин жилд аймаг байгуулагдсаныхаа түүхт 90 жилийн ойг хамтдаа өргөн дэлгэр тэмдэглэж, бүтээлч ажил үйлсээрээ “Монгол улсын шилдэг аймаг” болж, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор шагнагдсан, амжилт бүтээлийн арвин сайхан жил байлаа.

Увс нутгийн эрдэм чадал, авьяас билэгт, оюунлаг охид, хөвгүүд, эх орныхоо өнцөг булан бүрт ажил үйлсээрээ манлайлж төрөлх аймгийнхаа нэрийг өндөрт өргөж явааг та бүхэнд дуулгахад таатай байна.

Та бүхэн хотол түмнээрээ сар шинэдээ сайхан шинэлээрэй.

Увс аймгийн ИТХ-ын дарга Чулууны Чимэд

БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛУУД ХУРАЛДЛАА.

Монгол түмний баяр болох сар шинийн босгон дээр багийн Иргэдийн Нийтийн Хурлууд зохион байгуулагдаж байна. Увс аймгийн 19 сумын 93-н багийн Иргэдийн Нийтийн Хурал энэ сарын 01-ээс 05-ны өдрүүдэд хуралдаж дуусах бөгөөд

багийн хуралд аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Засаг дарга Д.Цэндсүрэн болон ИТХ-ын нарийн бичгийн дарга, Засаг даргын тамгын газрын дарга, хэлтэс, агентлагийн дарга нар оролцож байна.



Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд 02-р сарын 01-03-ны өдрүүдэд Бөхмөрөн сумын Гурван жигэртэй, Хар алтат, Байшинт багийн ИНХ-д оролцож төр засгийн бодлого шийдвэр, хэрэгжилтийн талаар мэдээлэл танилцуулга хийн иргэдийн санал, хүсэлтийг сонсож ажиллалаа.

Мөн сар шинийн босгон дээр аймгийн сайн малчин, аймгийн алдарт уяач цолоор шагнагдсан иргэдийн шагналыг гардуулан өглөө.

Аймгийн сайн малчин цолоор Гурван жигэртэй багийн малчин Д.Лувсандорж, Хар алтат багийн малчин Г.Пунцагсүрэн, Б.Нямбаяр, аймгийн алдарт уяач цолоор Хар алтат багийн уяач С.Галбадрах нар шагнагдсан байна. Мөн энэ үеэр сумын сайн малчин болон сумын алдар уяач цол тэмдэгээр болзол хангасан нэр бүхий иргэдийг шагнаж урамшууллаа.

АЙМГИЙН ИТХ-ЫН АЖЛЫН АЛБА АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ.



XVII жарны гал бичин жилийн босгон дээр аймгийн Иргэдийн Төлөөлөгдийн Хурлын ажлын албанд олон жил ажиллан гавьяаныхаа амралтанд суугаа ахмад буурлууддаа аймгийн ИТХ-ын ажлын албаны зүгээс хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа.

НӨУБ-ЫН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон ЗДТГ-ын хамтарсан хяналт шинжилгээ, мониторингийн ажлын хэсэг Увс аймгийн 18-н суманд 2015 оны 11 сарын 09-14-ний өдрүүдэд ажиллаж сумдын төрийн



байгууллагын ажлын зохион байгуулалтыг дүгнэж, аймаг, сумын ИТХ-ын бодлого шийдвэр, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, архив албан хэрэг хөтлөлт, төрийн албаны стандартын хэрэгжилт, нийгмийн хөгжлийн бодлого шийдвэрийн хэрэгжилт ОНХС-ын бодлого шийдвэрийн хэрэгжилт, хууль эрх зүйн бодлогын хэрэгжилт, төсөв санхүүгийн бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан билээ.

Аймгийн ИТХ дээрх хяналт, мониторингийн үнэлгээгээр нутгийн өөрөө удирдах байгууллагын шилдгүүдээ тодруулж аймгийн ИТХ-ын дээд шагнал “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”, мөнгөн шагналаар шагнав. 2015 оны ажил үйлсээрээ НӨУБ-ын “ШИЛДЭГ УДИРДАГЧ”-аар Бөхмөрөн сумын ИТХ-ын дарга Б.АЛДАРЖАВХЛАН, “ШИЛДЭГ АЖИЛТАН”-аар Зүүнговь сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ж.БАЯНТӨР нар шагнагдлаа.

АХМАД БУУРЛУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ.

XVII жарны “Муу нүүрт” хэмээх Гал бичин жилийн сар шинийн



босгон дээр Монгол улсын Ерөнхийлөгч Монголын Чахиагийн Элбэгдорж 100 болон түүнээс дээш насны ахмадууддаа гарын бэлэг явуулсныг аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд гардуулан өглөө.

Одоогийн

байдлаар улсын хэмжээнд 97 болон түүнээс дээш настай буурлууд 110 байдаг бөгөөд манай аймгийн хэмжээнд 100 нас хүрч байгаа 2 буурал байдаг ажээ.

Гэвч овогтой Цэжин нь Бөхмөрөн сумын Хар алтат багт, Үлэмж овогтой Чулуун нь Тариалан сумын 5-р багт амьдарч байна.

Г.Цэжин гуай 1916 онд одоогийн Бөхмөрөн сумын нутагт малчин ард Гэзээн том охин болон төрсөн бөгөөд эцэг эхээс гурвуулаа эрэгтэй, эмэгтэй 2 дүүтэй. Тэрээр 13 настайгаасаа эхлэн мал малласан бөгөөд насаараа нэгдэл болон хувийн мал маллан, саальчин хийж байгаад өндөр насны тэтгэвэрт гарчээ. Г.Цэжин гуай хоёр охин нэг, хүү төрүүлж өсгөсөн бөгөөд одоо том охин нь 73 настай Улаанбаатар хотод амьдарч байгаа бөгөөд дунд хүү нь ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн байна. Бага охин нь 65-н настай одоогоор ээжийнхээ хамт Хар алтат багийн нутаг Хадаан усан нэртэй газар тарган сайхан өвөлжиж байна.

Хоёр хөл хөшиж өвддөг, нүдний хараа муудсанаас өөр өвчин зовлон алга хэмээн настан маань хуучилсан юм.

Амьдралдаа үзсэн хамгийн хүнд үеэ 13 настай /1929/ байхад эхэлсэн Комо /Коммун байгуулагдав/ байлаа. Ноёдыг бүрэлгэж малыг нь хураасан энэ ажил 3 жил үргэлжилснийг харуусан дурсан ярьлаа.



“УЛСЫН САЙН МАЛЧИН”, “ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ”, “ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛНЫГ” ШАЛГАРУУЛЛАА



Энэ онд Манай аймгаас “УЛСЫН САЙН МАЛЧИН” цолоор

Увс аймгийн Наранбулаг сумын Алдар багийн малчин Пүрэвийн Даш,

Малчин сумын Баян-Эрдэнэ багийн малчин Бадрахын

Баттогтох,

Хяргас сумын Хайрхан багийн малчин Цэндийн

Сүрэнхор,

Зүүнговь сумын Суварга багийн малчин Лувсангийн Дансран,

Зүүнговь сумын Тохой багийн малчин Шагжийн Баатаржав

"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН"-оор

Увс аймгийн Тариалан сумын "Алдар тулга" ХХК

"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ"-аар

Увс аймгийн Хяргас сумын иргэн Палиагийн Оюунбилэг нар шалгарлаа.



ИТХ-ЫН ДАРГА СОЛОНГОС УЛСАД НӨУБ-Д ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДЛААР ТҮРШЛАГА СУДЛАЛАА.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НУБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах



байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, зарим аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга нар болон албаны бусад хүмүүс нутгийн удирдлагын туршилага суулахаар 2016 оны 02 дугаар сарын 15-наас 21-ний хооронд Бүгд Найрамдах Солонгос улсад ажиллалаа.

ДАВСТ СУМ

2-р сарын 1-3-ны өдрүүдэд багийн ИНХ-ыг хөдөө багуудад хэсэгчлэн Хандгайт багт Ганжуур залдаг,



Хандгайтын эхэн, Аараг, Торхилог багт Сэвхүүл, Хатуугийн уул гэсэн чиглэлд хуралдуулж,

оны аварга тэргүүнээ шагнаж, урамиуулав. Мөн энэ үеэр сумын ИТХ-ын 10-р хуралдаанаар БНМАУ-ЫН АВАРГА малчин Ц.Баянзулын нэрэмжит шагнал бий болгосноор 2 залуу малчинг болзлын дагуу шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав. Цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн малчдад ОНХ-н сангаас 19335200 төгрөгийг өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхээр хуваарилснаас өвс тэжээл авч хүндэрч буй малчдад хүргүүлэх ажлыг зохион байгуулав. Үүнд 2-р сард 30 тн тэжээл/ 1200 уут/, 3905 ш / өвс ирснийг ЗДТГ-хан хуваарилаж, малчин болон мал бүхий өрхүүдэд тарааж байна.

ӨМНӨГОВЬ СУМ

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар ажлын албаны 2016 онд хийх ажлын төлөвлөгөө, сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төвийг байгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. БИНХ-уудыг 2-р сарын 2-ноос 6-ны хооронд зохион байгуулж нийт 320 гаруй иргэдийг хамруулан сумын ИТХ-ын ажлын албаны 2015 оны тайлан, үйл ажиллагааны мэдээллийг багуудын хуралд тавьж иргэдийн сонирхсон асуултад хариуллаа.



САГИЛ СУМ:

Цаг үе өвөлжилт хүндэрч байгаа учраас аймгаас

ОБГазраас өвс 1500 ширхэг боодол, 12 тонн тэжээлийн хангалтын арга хэмжээнд оролцож, малчдын



хүндэрсэн зарим хот айлуудад өвс тэжээл хүргэх ажлыг зохион байгуулав. “Сурагчийн нэг өдөр” төрний захиргааны албан хаагчдын ажлын нэг өдөрт сурагчийн оролцоо арга хэмжээ зохион байгуулсан.

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг Ө.Бадрахын гудамж, ЗДТГ-ын байр 210тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uv.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал